

2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ЦЭХ-НИЙ БОЛОВСРУУЛАЛТ

2025 оны гүйцэтгэлээр 166.0 сая кВт.ц цахилгаан эрчим хүч боловсруулснаас дотоод хэрэгцээндээ 18.59 сая кВт.ц буюу 11.20 хувийг нь зарцуулж 147.4 сая кВт.ц цахилгаан эрчим хүч түгээж бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 104.1 %-н гүйцэтгэлтэй биелүүлсэн байна.

График 1



ЦЭХ –НИЙ ТҮГЭЭЛТ:

14,7453.4 мян квт ц ЦЭХ түгээсэн нь төлөвлөгөөнөөс 5,754 мян квт ц-аар илүү буюу 104.1% биелсэн ба урьд оноос 7911.4 мян квт ц эрчим хүч дутуу түгээж 94.9 %-н гүйцэтгэлтэй гарсан байна. Тайлант онд ТГ№1-д 08 сарын 11-ээс 10 сарын 18-ны хооронд хийгдэж дууссан ба 5 сарын 27-оос 6 сарын 03-ны хооронд 173 цаг станц “Бүрэн зогсолт” хийгдсэн байна. Мөн Бөөрөлжүүтийн цахилгаан станц ашиглалтад орсноор 08 сарын 03-аас 08 сарын 11-ны хооронд 186 цаг хэрэглээ буурч ТГ№2-г бэлтгэлд зогсоосон байна.




График 2. Цахилгаан эрчим хүчний түгээлт

ДХЦЭХ:

2025 оны гүйцэтгэлээр нийт боловсруулсан цахилгаан эрчим хүчний 11.2 хувь буюу 18.598 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг хэрэгцээндээ зарцуулсан нь төлөвлөгөөнөөс 827 мян кВт.ц буюу 0.86 хувиар буурсан байна.




График 3. ДХЦЭХ

ДХЦЭХ-ний хувь хэмжээ энэ онд буурсан үзүүлэлттэй байгаа тоноглолын ачаалал авалт сайжирч түгээлт нэмэгдсэнээр хувь хэмжээ буурч харагдаж байна. Биетээр төлөвлөсөн хэмжээнээс 827 мян кВт-аар буурсан ба өмнөх оноос 1219 мян кВт-аар тус тус буурсан байна. 2025 онд К2-ын ажилласан цаг өмнөх жилүүдийнхээс өндөр байгаа боловч дотоод хэрэгцээний хувь хэмжээ хамгийн бага үзүүлэлт гарч байгаа нь К2-дээр хийгдсэн их засварын ажлаар утаа сорогчийн давтамж их байсан ба G циклоны бөөрөнхий нүхийг томруулж өгснөөр утаа сорогч дарж утааны хийн халуун 5-10 °C ээр буурснаар утааны хийтэй алдах алдагдал багасаж зуухны АҮК болон цахилгаан эрчим хүчний зарцуулалт буурсан байна.




График 4. ДХЦЭХ

ЖИШМЭЛ ТҮЛШНИЙ ХУВИЙН ЗАРЦУУЛАЛТ, НҮҮРСНИЙ ЗАРЦУУЛАЛТ

Жишмэл түлшний хувийн зарцуулалт 2025 онд ЦЭХ-нд 540.4 гр/кВт.ц гарсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 9.1 гр/кВт.ц-аар, төлөвлөсөн хэмжээнээс 64.4 гр/кВт.ц-аар тус тус хэмнэж, дулаанд 193.4 кг/Гкал гарсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 0.1 кг/Гкал-аар, төлөвлөгөөнөөс 4.2 кг/Гкал-аар тус тус буурч нийлбэр дүнгээр 10738 тн жишмэл түлш хэмнэсэн буюу бодит нүүрсээр 23582 тн хэмнэсэн




График 5. Жиимэл түлшний хувийн зарцуулалт

Түлшний хувийн зарцуулалт хэмнэсэн шалтгаан нь:

- Вакум:-0.131%-иар нэмэгдсэн
- УХЗ-0.04кВт/кг-аар буурсан
- Хослон үйлдвэрлэлийн хувь хэмжээ-8.2%-иар нэмэгдсэн
- Конденсатын алдагдал-0.4%-иар буурсан
- Зуухны АҮК-0.5%-иар нэмэгдсэн
- Нүүрсний дулаан гаргах чадвар төлөвлөсөн хэмжээнээс 143.6 ккал/кг-аар нэмэгдсэн.
- РОУ-н зарцуулалт 1542 тн-оор буурсан.




График 6. Жиимэл түлшний хувийн зарцуулалт задаргаа

2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Зорилтод түвшин:

Д/д	Үзүүлэлтүүд		х.н	2024 он гүйц	Тайлант он		Зөрүү	
					Төл	Гүйц	Хувь	Дүн
1	Боловсруулсан ЦЭХ		сая.квтц	175.2	161.1	166.1	103%	4.9
2	ДХЦЭХ	Биетээр	сая.квтц	19.8	19.4	18.6	96%	(0.8)
		Хувиар	хувь	11.3%	12.1%	11.2%	93%	(0.0)

КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

3	Эрчим хүч түгээлт Цахилгаан	сая.квтц	155.36	141.7	147.45	104%	5.8
	Дулаан	мян.Гка	260.8	243.6	247.4	102%	3.8
4	Нийт орлого	сая.төг	39,096.5	43,189.7	44,728.1	104%	1,538.5
	Үүнээс: Борлуулалт	сая.төг	37,804.0	42,889.7	44,210.9	103%	1,321.2
5	Нийт зардал	сая.төг	38,975.6	46,264.5	44,143.5	95%	(2,121.1)
	Үүнээс: УАБ зардал	сая.төг	417.9	250.0	167.3	67%	(82.7)
6	Ашиг / алдагдал /	сая.төг	121.0	-3,074.8	584.7	-19%	3,659.5
	Цэвэр ашиг / алдагдал /	сая.төг	106.1	-3,074.8	571.6	-19%	3,646.4
7	Борлуулалтын 1 төг-т ногдох зардал	төг	1.0	1.1	1.0	92%	(0.1)
8	Авлага	сая.төг	1,651.9	682.5	4,421.4	648%	3,738.9
9	Өглөг	сая.төг	1,276.4	1,475.0	669.6	45%	(805.4)
	Үүнээс: Богино хугацаат өглөг	сая.төг	962.6	1,175.0	397.7	34%	(777.3)
10	ХО, ИЗ, ТЗБАХ	сая.төг	2,215.2	3,919.6	3,503.1	89%	(416.5)
11	Жишмэл түлшний зарцуулалт ЦЭХ	гр/квтц	549.4	604.7	540.4	89%	(64.4)
	ДЭХ	кг/Гкал	193.5	197.6	193.4	98%	(4.2)
12	Нийт ажиллагсдын тоо	тоо	290	313	280	89%	(33.0)
13	Нийт цалингийн сан	сая.төг	13,292.2	16,045.9	15,310.7	95%	(735.2)

1. Нийт орлого:

Тайлангийн хугацаанд: Цахилгаан эрчим хүчний орлого 42,448.6 сая.төг, Дулааны эрчим хүчний орлого 1,762.3 сая.төг, Үйл ажиллагааны бус орлого 517.3 сая.төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй гарсан бөгөөд нийт орлогын дүн **44,728.1 сая.төг** байна.


Нийт борлуулалтын орлогын төлөвлөгөөтэй харьцуулахад 1,538.5 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлогын 96 хувийг ЦЭХ-ний, 4 хувийг ДЭХ-ний орлого эзэлж байна.

2. Нийт зардал:

Зардлын задаргаа:

Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Түлшний зардал	16,936,182.8	16,736,121.7	(200,061.1)
Шатахууны зардал	252,782.3	203,026.2	(49,756.1)
Урсгал засвар	644,450.0	644,289.4	(160.6)
Үндсэн ба нэмэгдэл цалин	15,868,307.6	15,109,076.0	(759,231.7)
Бусад зардлууд	5,149,673.9	4,793,242.3	(356,431.6)
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	5,398,863.8	5,072,558.1	(326,305.7)
Ажиллагсдын нийгмийн зардал	1,764,264.9	1,417,842.4	(346,422.5)
Үйл ажиллагааны бус зардал	250,000.0	167,315.7	(82,684.3)
Нийт дүн	46,264,525.3	44,143,471.7	(2,121,053.5)

Нийт зардалд эзлэх хувь**3. Ашиг алдагдал:**

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өссөн дүнгээр		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Үйл ажиллагааны ашиг алдагдал				
Нийт орлого	сая.төг	42,889.69	44,210.88	1,321.19
Нийт зардал	сая.төг	46,014.53	43,976.16	(2,038.37)
Ашиг, алдагдал	сая.төг	(3,124.84)	234.72	3,359.56
Үйл ажиллагааны бус ашиг алдагдал				
Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	300.0	517.3	217.3
Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	250.0	167.3	(82.7)
Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	сая.төг	50.0	349.9	299.9
		(3,074.8)	571.6	3,646.4

Цэвэр ашиг 571.6 сая төгрөг гарсан бөгөөд алдагдлыг **3,646.4 сая** төгрөгөөр бууруулсан байна.